



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 14 өдөр

Дугаар А/423

Улаанбаатар хот

Сургалтын төлөвлөгөө, санхүүжилтийн
эх үүсвэр, зардлын төсөв батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21⁸.4 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалт, "Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого батлах тухай" Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолын 2.4.3.4 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.1.11, 3.1.21 дэх заалт, "Хөрөнгө хуваарилах тухай" Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/341 дүгээр тушаал, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/312 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтныг 2017-2020 онд улсын төсвийн санхүүжилтээр гадаадын өндөр хөгжилтэй оронд төгсөлтийн дараахь сургалтанд хамруулах тэргүүлэх чиглэл"-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтны 2017-2018 оны гадаадын өндөр хөгжилтэй оронд төгсөлтийн дараахь сургалтанд суралцах төлөвлөгөө, санхүүжилтийн эх үүсвэрийг нэгдүгээр, сургалтын зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтанд заасан санхүүжилтийн эх үүсвэрийн дагуу гадаад сургалтын санхүүжилтийг шийдвэрлэхийг Төрийн нарийн бичгийн дарга, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн дарга /Д.Очирбат/-д, зөвхөн Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу гадаад сургалтыг хугацаанд нь хариуцлагатай зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д тус тус үүрэг болгосугай.

3. Эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтны гадаад сургалтыг эрүүл мэндийн салбарын бодлого, чиглэлтэй нийцүүлэн зайлшгүй шаардлагаар нэмэлтээр зохион байгуулах асуудлыг тухай бүр шийдвэрлэж, зохицуулалт хийж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.

4. Гадаад сургалтанд суралцах хугацаанд эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтны үүрэгт ажлыг зохицуулах, сургалтын үр дүнг тооцож, тухайн сургалт зохион байгуулагдсанаас хойш нэг сард багтаан Эрүүл мэндийн хөгжлийн төвд тайлагнахыг эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

5. Тушаалын дагуу эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтныг гадаадын өндөр хөгжилтэй оронд суралцуулах ажлыг зохион байгуулж, гадаад сургалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөл /Д.Очирбат/-д тайлагнахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/, сургалтын зохион байгуулалтанд явцын хяналт тавих, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/-т тус тус даалгасугай.

6. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж, гадаад сургалтын санхүүжилт, үр дүнд дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтыг хийж, Эрүүл мэндийн төвсийн Ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын хороонд танилцуулж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт/-д үүрэг болгосугай.

7. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/312 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

**ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭН, ЭРҮҮЛ МЭНДИЙН БУСАД АЖИЛТНЫ 2017-2018 ОНЫ
ГАДААДЫН ӨНДӨР ХӨГЖИЛТЭЙ ОРОНД ТӨГСӨЛТИЙН ДАРААХЬ СУРГАЛТАНД
СУРАЛЦАХ ТӨЛӨВЛӨГӨӨ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР**

Эрүүл мэндийн сайд
2017 оны 11 сарын 14 ны өдөр
4/423 дугаар тушаалын 1 дүгээр хавсра

№	Сургалтын чиглэл	Хариуцах байгууллагын нэр	Суралцах улс, байгууллага	Сургалтын үргэлжлэх хугацаа /хоног/	Суралцах мэргэжилтний тоо	Санхүүжилтийн эх үүсвэр
Нэг. Эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтныг 2017-2020 онд гадаадын өндөр хөгжилтэй оронд төгсөлтийн дараахь сургалтанд хамруулах тэргүүлэх чиглэлийн хүрээнд						
1.	Ясны чөмөг /аллотрансплантац/ шилжүүлэн суулгах, үүдэл эсийн банк байгуулах технологи	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	Бүгд Найрамдах Солонгос Улсын Католикийн их сургууль, Гэгээн Мария эмнэлэг	14 - 45 хоног	- Эрчимт эмчилгээний сувилагч 1 - Эрчимт эмчилгээний эмч 1 - Цус судлалын эмч 4 - Бөөр судлалын эмч 1 - Сувилагч 1 - Лабораторийн техникч 1 - Техникч 1	Төгсөлтийн дараахь сургалтын санхүүжилт
2.	Электрорфизиологийн оношилгоо эмчилгээ /аблаци/	Улсын гуравдугаар төв эмнэлэг	Бүгд Найрамдах Солонгос Улсын Корей сургуулийн Анам эмнэлэг	14 хоног	- Зүрх судлалын эмч 4 - Мэс заслын сувилагч 1 - Эмнэлгийн тоног төхөөрөмжийн техникч 2	Төгсөлтийн дараахь сургалтын санхүүжилт

3.	Мөчдийн хавдрын оношлогоо, эмчилгээ	Гэмтэл согог судлалын үндэсний төв	Бүгд Найрамдах Солонгос Улсын Хавдар судлалын үндэсний төв	30хоног	- Мэс заслын эмч 1	Төгсөлтийн дараахь сургалтын санхүүжилт
4.	Хавсарсан хүнд гэмтлийн үеийн мэс засал /Цээжний хүнд гэмтэл/	Гэмтэл согог судлалын үндэсний төв	Бүгд Найрамдах Солонгос Улсын Хана эмнэлэг	45хоног	- Гэмтэл согогын эмч 3 - Гэмтэл согогын сувилагч 1 - Эрчимт эмчилгээний эмч 1 - Эрчимт эмчилгээний сувилагч 1	Төгсөлтийн дараахь сургалтын санхүүжилт
5.	Элэг шилжүүлэн суулгах мэс засал	Хавдар судлалын үндэсний төв	Бүгд Найрамдах Солонгос Улсын Самсунг эмнэлэг	14 хоног	- Мэс заслын эмч 3 - Мэдээгүйжүүлэгийн эмч 2 - Эрчимт эмчилгээний эмч 2 - Элэг судлалын эмч 1 - Анатомийн эмгэг судлалын эмч 1 - Эмнэлзүйн эмгэг судлалын эмч 1 - Эмнэл зүйн эм зүйч 1 - Дүрс оношилгооны эмч 1 - Мэдээгүйжүүлгийн сувилагч 1 - Мэс заслын сувилагч 1 - Эрчимт эмчилгээний сувилагч 1	Төгсөлтийн дараахь сургалтын санхүүжилт

6.	Иммуногисто-химийн эмгэг судлалын шинжилгээ	Эмгэг судлалын үндэсний төв	Япон Улс	30 хоног	- Анатомийн эмгэг судлалын эмч 1 - Лабораторийн техникч 1	Төгсөлтийн дараахь сургалтын санхүүжилт
7.	Халдварт өвчний үүсгэгчийн генийн дараалал тогтоох арга зүй	Зоонозын өвчин судлалын үндэсний төв	Бүгд Найрамдах Солонгос Улсын Чосоны их сургууль	180 хоног	- Генетикч 1 - Вирусологич 1	Төгсөлтийн дараахь сургалтын санхүүжилт

Хоёр. Эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтныг гадаадын өндөр хөгжилтэй оронд төгсөлтийн дараахь сургалтанд бусад чиглэлээр хамруулах

8.	Эх барих, эмэгтэйчүүдийн эмч, эх баригч нарт зориулсан эмнэлгийн мэргэжилтний ёс зүй	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, нийслэлийн 3 амаржих газар болон Япон Улсын ЖАЙКА байгууллагаас зохион байгуулах "Эсэн мэнд амаржихууд чиглэсэн эх барих, эмэгтэйчүүдийн эмч, эх баригч нарын сургалт"- төсөлд хамрагдахгүй бусад 11 аймгийн нэгдсэн эмнэлэг	Япон Улс	7 хоног	- Эх барих, эмэгтэйчүүдийн эмч 1 (байгууллага тус бүрээс) - Эх баригч 1 (байгууллага тус бүрээс)	Төгсөлтийн дараахь сургалтын санхүүжилт
9.	Шүдний анхан шатны тусламж үйлчилгээ	Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөл	Япон Улс	7 хоног	- Шүдний эмч 30	Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө
10.	Эрүүл мэндийн удирдлага	Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөл	Америкийн Нэгдсэн Улсын Стэнфордийн Их сургууль	10 хоног	- Удирдах түвшний менежер 10	Төгсөлтийн дараахь сургалтын санхүүжилт, Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө

11.	Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо	Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөл	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Берлин хот	7 хоног	- 10	Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө
12.	Эрүүл мэндийн удирдлага	Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөл	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Берлин хот	7 хоног	- 10	Төгсөлтийн дараахь сургалтын санхүүжилт, Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө
13.	Хиймэл үе суулгах мэс засал	Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөл	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Хамбург хот	7 хоног	- 10	Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө
14.	Сургалт эрхлэх байгууллагын төгсөлтийн дараахь сургалтыг зохион байгуулах чадавхийг сайжруулах сургалт	Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөл	Япон Улс	7 хоног	- Сургалт эрхлэх байгууллагын сургалтын асуудал хариуцсан мэргэжилтэн 30	Төгсөлтийн дараахь сургалтын санхүүжилт
15.	Эрүүл мэндийн байгууллагын урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Нийслэлийн эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн төв	Япон Улс	7 хоног	- Удирдах түвшний менежер 15	Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө
Гурав. Монгол Улсад оношлох, эмчлэх боломжгүй болон ховор тохиолдох өвчний оношилгоо, эмчилгээний чиглэлээр гадаад орны өндөр ур чадвартай эмнэлгийн мэргэжилтнийг урьж ажиллуулах хүрээнд						
16.	Эх барих, эмэгтэйчүүдийн эмч, эх баригч нарт зориулсан ёс зүй,	Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөл	Япон Улс	6 хоног	- 2 гадаадын эмнэлгийн мэргэжилтэн	Төгсөлтийн дараахь сургалтын санхүүжилт

	харилцааны сургалт					
17.	Шүдний анхан шатны тусламж үйлчилгээ	Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөл	Япон Улс	5 хоног	- 3 гадаадын эмнэлгийн мэргэжилтэн	Төгсөлтийн дараахь сургалтын санхүүжилт

Эрүүл мэндийн сайд
2017 оны 11 сарын 14 нд өдөр
дугаар тушаалын 2 дугаар хавсра
А/413

ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭН, ЭРҮҮЛ МЭНДИЙН БУСАД АЖИЛТНЫ 2017-2018 ОНЫ ГАДААДЫН ӨНДӨР ХӨГЖИЛТЭЙ
ОРОНД ТӨГСӨЛТИЙН ДАРААХЬ СУРГАЛТАНД СУРАЛЦАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Нэг. Эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтныг 2017-2020 онд гадаадын өндөр хөгжилтэй оронд төгсөлтийн дараахь гадаад сургалтын хамруулах тэргүүлэх чиглэлийн хүрээнд зохион байгуулах сургалтын зардлын төсөв

Суралцах улс	Сургалтын чиглэл	Сургалтанд хамрагдах хүний тоо	Сургалтын үргэлжлэх хугацаа (хоног)	Зам хоног, унааны нийт зардал /1 хүний 25 ам доллар/	Онгоцны билетний нийт зардал /1 хүний хувьд 1,600,000 төгрөг/	Бүгд зардал /төгрөг/
Бүгд Найрамдах Солонгос Улс	Ясны чөмөг /аллотрансплантац/ шилжүүлэн суулгах, үүдэл эсийн банк байгуулах технологи	3	45	8,284,477.50	4,800,000.00	13,084,477.50
	Ясны чөмөг /аллотрансплантац/ шилжүүлэн суулгах, үүдэл эсийн банк байгуулах технологи	7	14	6,013,917.00	11,200,000.00	17,213,917.00
	Электробиологийн оношилгоо эмчилгээ /аблаци/	7	14	6,013,917.00	11,200,000.00	17,213,917.00
	Мөчдийн хавдрын оношлогоо, эмчилгээ	1	30	1,840,995.00	1,600,000.00	3,440,995.00
	Хавсарсан хүнд гэмтлийн үеийн мэс засал /цээжний хүнд гэмтэл/	6	45	16,568,955.00	9,600,000.00	26,168,955.00
	Элэг шилжүүлэн суулгах мэс засал	15	14	0	24,000,000.00	24,000,000.00

	Халдварт өвчний үүсгэгчийн генийн дараалал тогтоох арга зүй	2	180	22,091,940.00	3,200,000.00	25,291,940.00
Япон Улс	Иммуногисто- химийн эмгэг судлалын шинжилгээ	2	30	4,418,388.00	3,600,000.00	8,018,388.00
Нийт дүн		43		65,232,589.5	69,200,000	134,432,589.5

Хоёр. Эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтныг гадаадын өндөр хөгжилтэй оронд төгсөлтийн дараахь сургалтанд бусад чиглэлээр суралцуулах сургалтын зардлын төсөв

Суралцах улс	Сургалтын чиглэл	Сургалтанд хамрагдах хүний тоо	Сургалтын үргэлжлэх хугацаа (хоног)	Зам хоног, унааны нийт зардал /төгрөг/*	Онгоцны билетний нийт зардал /төгрөг/**	Бусад зардал /виз, эрүүл мэндийн даатгал, хот хоорондын унааны зардал/ /төгрөг/	Бүгд зардал /төгрөг/
Япон Улс	Эх барих, эмэгтэйчүүдийн эмч, эх баригч нарт зориулсан эмнэлгийн мэргэжилтний ёс зүй	28	7	129,900,607	50,400,000	4,355,304	184,655,912
	Шүүдний анхан шатны тусламж үйлчилгээ	30	7	139,179,222	54,000,000	4,666,398	197,845,620
	Сургалт эрхлэх байгууллагын төгсөлтийн дараахь сургалтыг зохион байгуулах чадавхийг сайжруулах сургалт	30	7	139,179,222	54,000,000	4,666,398	197,845,620
	Эрүүл мэндийн байгууллагын урьдчилан сэргийлэх арга хэмжээ	15	7	69,589,611	27,765,000	2,333,199	99,687,810

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо	10	7	37,801,764	21,350,000	2,496,024	61,647,781
	Эрүүл мэндийн удирдлага	10	7	37,801,764	21,350,000	2,496,024	61,647,781
	Хиймэл үе суулгах мэс засал	10	7	37,801,764	26,351,000	12,314,664	76,467,428
Америкийн Нэгдсэн Улс	Эрүүл мэндийн удирдлага	10	7	46,393,074	49,720,000	3,932,058	100,045,132
Нийт дүн		143	56	637,401,562	304,936,000	37,260,069	979,843,091

* Япон Улс, Америкийн Нэгдсэн Улс - 1 хүний 70 ам доллар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс -50 ам доллараар тус тус тооцов.

** Япон Улс, Токио хот - 1 хүний 1,800,000 төгрөг, Япон Улс, Нагояа хот - 1 хүний 1, 851, 000 төгрөг, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Берлин хот - 1 хүний 2,100,000 төгрөг, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Хамбург хот - 1 хүний 2,635,100 төгрөг, Америкийн Нэгдсэн Улс, Сан-Франциско хот - 4,972,000 төгрөгөөр тус тус тооцов.

Гурав. Монгол Улсад оношлох, эмчлэх боломжгүй болон ховор тохиолдох өвчний оношилгоо, эмчилгээний чиглэлээр гадаад орнонд ур чадвартай эмнэлгийн мэргэжилтнийг урьж ажиллуулах хүрээнд

Гадаадын эмнэлгийн мэргэжилтний харьяалал	Сургалтын чиглэл	Монгол Улсад ирж ажиллах гадаадын эмнэлгийн мэргэжилтний тоо	Сургалтын үргэлжлэх хугацаа (хоног)	Зочид буудал, зам хоногийн нийт зардал /төгрөг/*	Онгоцны билетний нийт зардал /төгрөг/**	Бүгд зардал /төгрөг/
Япон Улс	Эх барих, эмэгтэйчүүдийн эмч, эх баригч нарт зориулсан ёс зүй, харилцааны сургалт	2	6	4,645,728	0	4,645,728
	Шүүдний анхан шатны тусламж үйлчилгээ	3	5	5,807,160	5,400,000	11,207,160
	Нийт дүн	5	11	10,452,888	5,400,000	15,852,888
НИЙТ ДҮН		191		1,130,128,575.00		